

FOR INTERNAL USE ONLY

КОМПАНИЙН ТУХАЙ

Байгуулагдсан: 2005
ХК болсон: 2023

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	%	Хойш
Л. Ганзоригт	27.9%	2005
Б. Тэлэнгэд	27.9%	2005
Олон нийт	15.0%	2023
Г. Хишигбат	8.0%	2016
А. Одгэрэл	8.0%	2015
Л. Эрдэнэсоёл	3.8%	2015
Н. Алтанзул	3.8%	2015
Н. Эрдэнэбилэг	3.8%	2015

Менежмент:
Гүйцэтгэх захирал: Г. Хишигбат
12+ жилийн туршлага
LinkedIn: Khishigbat Ganzorigt

Гүйцэтгэх удирдлагын баг:
5 гишүүн
10+ жилийн туршлага

Ажилчид: 180 гаруй
Эмэгтэй: 68%
Эрэгтэй: 32%

Олон улсын стандарттай нийцсэн байдал:
CTISO 9001:2008 Чанарын удирлага
Төмөр замын аюулгүй ажиллагааны тусгай зөвшөөрөл
FIATA гишүүн

ПОРТФОЛИО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СЕГМЕНТ	2024.Н1 (мян.тн)	Зах зээлд эзлэх %
Импорт	51	1.6%
Транзит	404	15.3%
Экспорт	111	0.2%
Бусад	4	-

Эх сурвалж: Компанийн өөрийн тооцоолол

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД

Харьцаанууд	2023.Н1	2024.Н1
Үйл ажиллагааны ашгийн маржин	5.7%	5.3%
Нийт хөрөнгийн өгөөж ROA (%)	10%	7.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE (%)	15.7%	14%
Авлагын дүн	25.6	39.5
Эргэлтийн харьцаа	2.84	2.19
Өр ба өөрийн хөрөнгийн харьцаа	57%	80%
Өрийн харьцаа	0.36	0.44

Эх сурвалж: Хагас жилийн тайлан

ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

- Монложистикс Групп тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагааныхаа зах зээлийг тэлж, ТЭСО Группийн охин компани болох "Төв Азийн Зам" ХХК-ийн хувьцааг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51 хувийг өөртөө нэгтгэлээ.
- Вагоны худалдан авалтууд хийгдэж эхэлсэн ба эхний ээлжний 10 ширхэг вагон нь 2024 оны 8-р сард Монгол улсад импортлон орж ирэхээр байна. Дараагийн 40 ширхэг вагоны гэрээ хэлэлцээрийн шатанд явж байна.

Тээврийн ложистикийн салбарын анхны нээлттэй ХК

Монложистикс групп нь 2005 оноос эхлэн тээвэр ложистикийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд өдгөө 1 толгой компани, 10 охин компани, 180 гаруй ажилтан, 163 орны 800 гаруй түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй салбартаа тэргүүлэн ажиллаж байна. Компани 2005 онд 30 сая төгрөгийн анхны хөрөнгө оруулалттайгаар эхэлж өдгөө 19 жилийн дараа 67 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй нээлттэй хувьцаат компани болж өргөжин тэлсэн байна.

Монложистикс групп нь өргөн сүлжээ, тууштай баг, салбартаа олон жилийн турш үйл ажиллагаагаа явуулж буйгаараа дамжуулан салбарын төрөлжсөн сегментүүдэд найдвартай, шинэлэг тээвэр ложистикийн үйлчилгээг үзүүлж байна.

Компани нь өөрийн охин компаниудад Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, Бизнес хөгжил, Ложистик 6 чиглэлд олон улсын менежментийн үйлчилгээг чанартай үзүүлэхээс гадна, шинэ бизнес төслийг үргэлж эрэлхийлж, Группийг нэг бодлого, зарчимд зангидаж, нэгдсэн стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг толгой компани юм.

Алсын хараа, стратеги

Монложистикс Групп нь өөрийн алсын хараа 2030-ын хүрээнд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгохоор зорьж байна. Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд 2022 оноос эхлэн цогц шат дараатай ажлуудыг төлөвлөн хэргжүүлж байгаа бөгөөд нээлттэй Хувьцаат Компани болох нь урт хугацааны зорилгоо хүрэх ажлын нэгэн томоохон хэсэг байсан. Цаашид компани дэд бүтэцийн төслүүдийг эхлүүлэх, гадаадын зах зээлт тэлж борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх, олон улсын зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх зэрэг томоохон ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Группийн бүтэц



Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Сая ₮	2022.Н1	2023.Н1	2024.Н1
Нийт хөрөнгө	39,051	45,747	85,923
Нийт өр төлбөр	15,329	16,606	38,168
Өөрийн хөрөнгө	22,267	26,237	41,604
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,455	2,904	6,150

Орлогын бүтэц

Сая ₮	2022.Н1	2023.Н1	2024.Н1
*Борлуулалтын орлого	65,875	91,497	141,982
Борлуулалтын өртөг	(58,801)	(82,663)	(130,264)
Үйл ажиллагааны ашиг	3,115	5,218	7,562
Цэвэр ашиг	2,667	4,577	6,646


*Тохируулах бичилт хийгдсэн

Монголын Улсын тээвэр ложистикийн салбар


Тээвэр ложистикийн салбар нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил болон өсөлтийг хангах стратегийн онцгой ач холбогдолтой юм. Сүүлийн 5 жилийн хугацаанд тээврийн салбарын тээвэрлэсэн ачааны хэмжээ 1.6 дахин өсч 107.4 сая тонн болсон ба тээврийн нийт орлогын хэмжээ 3.8 дахин өсч, 7.5 их наяд төгрөгт хүрээд байна. Энэхүү өсөлт нь бусад салбарын болон зах зээлийн өсөлтийг дагаж үзүүлсэн органик өсөлт юм. Засгийн газрын боомтын сэргэлт, тээврийн сэргэлт зэрэг салбар луу чиглэсэн цогц бодлого болон дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь богино болон дунд хугацаанд салбарын өсөлтийг хадгалах хүлээлттэй байна.



Тээвэр, салбараар, %



Тээврийн нийт орлого, тээврийн төрлөөр




Эх сурвалж: Зам тээвэр хөгжлийн яамны албан ёсны вебсайт; 2023

Яагаад хөрөнгө оруулах вэ?

- Тээвэр ложистикийн салбар өсөлтийн мөчлөгт байгаа ба ЗГ бодлогын шинэчлэлт болон дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийж байна.
- Зах зээлийн тодорхой бус байдлыг даван туулах чадвартай, сайн төрөлжсөн ложистикийн портфолио.
- Санхүүгийн тогтвортой өсөлт
- Туршлагатай удирдлагын баг: Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын баг нь салбарын туршлагатай экспертүүдээс бүрдсэн.
- Стратегийн өндөр ач холбогдолтой төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадамжтай. Үүнд томоохон хөдлөх хөрөнгийн худалдан авалт хийх, М&А хийх зэрэг үйл ажиллагаа.

Зах зээл



Монложистикс Холдинг ХК

